



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20²⁴ оны 02 сарын 23 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр батлах тухай


Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1.11 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалын хууль эрх зүйн орчин, ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх зорилготой 2024-2025 онд хэрэгжүүлэх "Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Алимаа/, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/ болон Салбарын хяналтын газар /Б.Нарангаав/ -т тус тус даалгасугай.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, тогтмол тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /З.Энхболд/-т үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД

Х.БУЛГАНТУЯА





Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн
03 дугаар тогтооолын хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

1.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчдод хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах, хөдөлмөрийн харилцааны мэдээллийн цахим үйлчилгээ үзүүлж, ажил олгогч, ажилтны хоорондын хөдөлмөр эрхлэлтийн харилцааны зөв соёлыг төлөвшүүлэх, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжихэд чиглэгдэнэ.

Хоёр. Хамрах хүрээ, тавигдах шаардлага

Хөтөлбөрт дараах иргэн, аж ахуйн нэгжийг хамруулна:

2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар зөвлөх үйлчилгээнд 50 хүртэл ажилтантай жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана. Ажил олгогчид чиглэсэн хөдөлмөрийн харилцааны сургалтад аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны тоо харгалзахгүйгээр хүсэлтийг үндэслэн хамруулна.

2.2. Хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага 2 жилд нэгээс илүүгүй удаа хөдөлмөрийн харилцааны асуудлаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд, ажил олгогчид чиглэсэн хөдөлмөрийн харилцааны сургалтад жилд хоёроос илүүгүй хамрагдах эрхтэй.

2.3. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллага, төрийн бус байгууллагыг хөтөлбөрийн хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээний арга хэмжээнд хамруулахгүй.

2.4. Хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөгч нь Монгол Улсын иргэн байна.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөрийн харилцааны дараах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлнэ:

3.1.1. хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний журам, ажилтны мэдээлэл авах, хадгалах, ашиглах журам зэрэг дотоод хэм хэмжээг боловсруулах;

3.1.2. хөдөлмөрийн гэрээ, түүний төрөл, хэлбэр, хэрэглээ, хөдөлмөрийн маргаан зохицуулах;

3.1.3. цалин хөлс, үндсэн болон нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцох;

3.1.4. ажил, амралтын цагийн зохицуулах;

3.1.5. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөх;

3.1.6. нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэглээний талаар ажил олгогчдод мэргэжлийн зөвлөх үйлчилгээ;

3.1.7. хөдөлмөрийн харилцааны бусад асуудал.

Хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ нь ажлын 10 хүртэл өдөр байна.

3.2. Ажил олгогчид чиглэсэн сургалт /цахим, танхим/-д хамруулах:

3.2.1. Ажил олгогчдод зориулсан сургалт нь танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулагдах бөгөөд хөдөлмөрийн гэрээ, цалин хөлс, ажил

амралтын цаг, цалин хөлсний талаарх Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалт, дагалдан гарсан журам, аргачлал, нийгмийн даатгал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллагад хэрэгжүүлэх талаарх сургалтанд хамруулах арга хэмжээ багтана. Ажил олгогчид чиглэсэн сургалтыг шаталсан, модуль хэлбэрээр зохион байгуулна.

3.3.Хөдөлмөрийн харилцааны мэдээллийн цахим үйлчилгээ үзүүлэх:

3.3.1.Хөдөлмөрийн харилцааны мэдээллийг цахим болон зайнас /утсаар, цахим хэлбэрээр гэх мэт/ хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд гардаг түгээмэл асуудлаар мэдээлэл, зөвлөгөөг ажил олгогч, ажилтнуудад өгөх үйлчилгээ багтана.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

4.1.Хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

4.2. Аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөхөд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох зардлаас гадна харилцан тохиролцон ажлын хөлс нэмж олгож болно.

Тав. Удирдлага зохион байгуулалт, хэрэгжилт

5.1.Хөтөлбөрт заасан арга хэмжээг аймаг, орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс хөдөлмөрийн харилцааны асуудлаар мэргэшсэн зөвлөхөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

5.2.Хөдөлмөрийн харилцааны асуудлаар мэргэшсэн зөвлөх нь хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаар мэргэшсэн бакалавраас дээш боловсролын зэрэгтэй, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан сургалтад хамрагдан мэргэшсэн зөвлөхийн гэрчилгээтэй зөвлөх байна.

5.3.Хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг хөтөлбөрийн 2 дугаар зүйлд заасан шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч харьяалах аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст маягтын дагуу гаргана.

5.4.Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт гаргасан байгууллагын хөдөлмөрийн харилцааны маягтын дагуу түвшинг үнэлж, байгууллагын хүсэлтийг харгалзан Хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, ажил олгогчид зориулсан сургалтад хамруулах үйлчилгээг харилцан тохиролцсоны дагуу гэрээний үндсэн дээр үзүүлнэ. Хөтөлбөрт хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтэд үндэслэн хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээг тухайлсан чиглэлээр үзүүлж болно.

5.5.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах зөвлөхийг бэлтгэх сургалтын модул боловсруулж, сургалт зохион байгуулна. Зөвлөх үйлчилгээ болон сургалтыг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх мэргэшсэн зөвлөх, сургагч багш нарыг бэлтгэх, сургагч багшийн болон оролцогчийн гарын авлага бэлтгэх, хэвлэнэ.

5.6.Зөвлөх бэлтгэх сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан зөвлөхөөс хөтөлбөрт хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага сонголт хийж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, хамтран ажиллана. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөх хөтөлбөрт хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч болон аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс ажлын төлөвлөгөө, үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлтийг харилцан тохиролцсоны үндсэн дээр батална.

5.7.Хөдөлмөрийн харилцааны мэдээллийг цахим хэлбэрээр /утсаар, цахим хэлбэрээр гэх мэт/ хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд гардаг түгээмэл асуудлаар мэдээлэл, зөвлөгөөг ажил олгогч, ажилтнуудад өгөх үйлчилгээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс хэрэгжүүлнэ.

Зургаа. Хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1.Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт сар бүрийн 3-ны дотор, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд сар бүрийн 5-ны дотор тайлагнана.

6.2.Хэрэгжилтийн явцад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар болон Аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл хяналт хийх ба уг хяналтын удирдамжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар батална.

6.3.Хөтөлбөрийн хэрэгжилтийн захиргааны тайланг (санхүүжилтийн болон гүйцэтгэлийн) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хяналтын дүгнэлтийн хамт улирал тутам хүргүүлнэ.

6.4.Хяналт, шинжилгээ үнэлгээний албаны мэргэжилтэн үр дүнг баталгаажуулах зорилгоор үнэлгээ хийхдээ хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтантай уулзаж, ярилцлага хийх замаар баталгаажуулна.

----о0о----

ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГИЙН ХҮСНЭГТ

Дд	Арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (ҮДШҮ)-ийг хэрхэн гарах тухай тайлбар	2024 онд тавих ҮДШҮ-ийн доод тувшин	ҮДШҮ-ийг гаргах давтамж
Хөдөлмөрийн харилцааны түвшингүнэлэх	ХХҮГХ-ээс харилцааны түвшингүнэлэх ААНБ, ажил олгогчийн тоо	Хөдөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан ААНБ-ын хөдөлмөрийн түвшин тодорхойлж, маягтын дагуу гаргана.	Хөдөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан ААНБ-ын хөдөлмөрийн харилцааны тодорхойлж, маягтын дагуу гаргана.	Тухайн онд хөдөлмөрийн харилцааны үйлчилгээнд хамруулах боломжит ААНБ, ажил олгогчийн тоо	Улирал бүр
Хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ААНБ, ажил олгогчийн тоо	Хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ААНБ, ажил олгогчийн тоо	Хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээ зөвлөх авсан ААНБ, ажил олгогчийн тоог эдийн засгийн салбар, байгууллагын ажилтны тоогоор ялган гаргана.	Хөдөлмөрийн харилцааны зөвлөх үйлчилгээ зөвлөх баг, мэргэжилнээс авсан ААНБ, ажил олгогчийн тоог эдийн засгийн салбар, байгууллагын ажилтны тоогоор ялган гаргана.	Тухайн жилд зөвлөх үйлчилгээнд хамруулахаар төлөвлөсөн	Улирал бүр
Хөдөлмөрийн тогтоомжийн сургалтад /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалтад /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалтад /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалтад /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалтад /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалтад /танхимын болон цахим сургалт/
Хөдөлмөрийн тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Хөдөлмөрийн тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/
Нийгмийн даатгалын тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Нийгмийн даатгалын тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Нийгмийн даатгалын тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Нийгмийн даатгалын тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Нийгмийн даатгалын тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/	Нийгмийн даатгалын тогтоомжийн сургалт /танхимын болон цахим сургалт/
Утсаар мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ	Утсаар мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгоч, ажилтны тоо	Цахим хэлбэрээр хөдөлмөрийн харилцааны мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгоч, ажилтны тоо	Цахим хэлбэрээр хөдөлмөрийн харилцааны мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгоч, ажилтны тоо	Утсаар мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгогчийн тоог гаргана.	Утсаар мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгогчийн тоог гаргана.
Цахим хэлбэрээр мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ	Цахим хэлбэрээр мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгоч, ажилтны тоо	Цахим хэлбэрээр хөдөлмөрийн харилцааны мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгоч, ажилтны тоо	Цахим хэлбэрээр мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгоч, ажилтны тоо	Цахим хэлбэрээр мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгогч, ажилтны тоо	Цахим хэлбэрээр мэдээлэл, зөвлөгөө авсан ААНБ, ажил олгогч, ажилтны тоо